

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын  
хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/125/НА-СТА-ТШЗ

Чингис хот  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн Стандарт дүгнэлт аудит ХХК  
аудитор: Б.Наранцэцэг  
Утас: 99569960 Цахим хаяг: info@sda-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.22

№ 185

танай

ны №

-т

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ж.СУГАРРАГЧАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс 3,097,139.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 660,753.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,210.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,129.9 мянган төгрөг, нийт 3,763,233.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,516,419.4 мянган төгрөг зарцуулан, 28,415.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харилцах дансандаа 442,651.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар 8,140.4 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрч, 2,458.9 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 5,681.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

232502185

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 86 арга хэмжээ тусгагдаж, 93.2 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж. ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>300,932,760.82</b>	<b>528,792,768.71</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	195,837,684.47	442,651,475.85
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	195,837,684.47	442,651,475.85
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	195,837,684.47	442,651,475.85
31211	Төрийн сангийн харилцах	195,837,684.47	442,651,475.85
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	75,135,106.49	51,755,124.50
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	19,181,870.00	5,779,774.00
35110	Тусгай зориулалттай материал	16,252,370.00	4,104,774.00
35130	Эм боох материал	2,929,500.00	1,675,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	49,604,036.49	40,756,150.50
35410	Бичиг хэргийн материал	5,034,745.00	4,515,613.00
35420	Аж ахуйн материал	10,303,955.00	11,006,900.00
35450	Барилгын засварын материал	840,000.00	840,000.00
35460	Хүнсний материал	2,998,345.00	6,661,534.00
35470	Бусад хангамжийн материал	30,426,991.49	17,732,103.50
35600	Мал амьтад	6,349,200.00	5,219,200.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	29,959,969.86	34,386,168.36
36100	Барааны нөөц	29,959,969.86	34,386,168.36
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,670,127,291.24</b>	<b>11,637,314,355.29</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	11,670,127,291.24	11,637,314,355.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	11,592,991,291.24	11,560,178,355.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,384,374,789.00	11,435,176,145.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(312,602,443.40)	(618,416,452.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,736,434.00	29,736,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32,302,325.50)	(28,249,612.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	679,797,257.94	584,176,838.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(291,650,897.72)	(146,632,775.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	244,564,071.72	331,341,079.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(160,311,322.06)	(63,771,947.71)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,370,210.00	205,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(26,206,210.04)	(82,000.08)
39217	Ном	41,221,727.30	36,695,646.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	77,136,000.00	77,136,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	77,136,000.00	77,136,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>11,971,060,052.06</b>	<b>12,166,107,124.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>79,684,687.00</b>	<b>58,435,435.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	79,684,687.00	58,435,435.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	79,684,687.00	58,435,435.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	79,684,687.00	58,435,435.00
41361	Байгууллагад төлөх өглөг	79,684,687.00	58,435,435.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,891,375,365.06</b>	<b>12,107,671,689.00</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	11,891,375,365.06	12,107,671,689.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,651,465,570.52	1,651,465,570.52
51101	Өмч: - төрийн	1,651,465,570.52	1,651,465,570.52
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	9,816,876,732.82	10,033,173,056.76
51210	Өмнөх үеийн үр дүн	9,816,876,732.82	9,816,876,732.82
51220	Тайлант үеийн үр дүн	-	216,296,323.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	423,033,061.72	423,033,061.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>11,971,060,052.06</b>	<b>12,166,107,124.00</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>12,367,532,098.00</b>	<b>4,107,078,830.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,066,503,598.00</b>	<b>349,185,530.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,066,503,598.00</b>	<b>349,185,530.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,066,503,598.00	349,185,530.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,286,700.00	4,129,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	245,000.00	1,210,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,060,971,898.00	343,845,630.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,301,028,500.00</b>	<b>3,757,893,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,018,464,900.00</b>	<b>3,097,139,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,018,464,900.00	3,097,139,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>282,563,600.00</b>	<b>660,753,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	282,563,600.00	660,753,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,909,548,045.02</b>	<b>3,878,517,426.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,909,548,045.02</b>	<b>3,878,517,426.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,792,549,681.52</b>	<b>3,721,791,697.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,494,546,619.00</b>	<b>2,192,827,728.52</b>
210101	Үндсэн цалин	837,976,596.00	1,389,022,671.65
210102	Нэмэгдэл	465,971,335.00	738,211,906.87
210104	Урамшуулал	14,172,684.00	65,593,150.00
210105	Гэрээт ажлын хөлс	176,426,004.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>744,741,525.13</b>	<b>274,031,672.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	127,581,039.58	186,341,320.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,009,400.38	21,922,337.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,007,750.85	10,961,419.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,001,765.08	10,961,419.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,018,926.24	43,845,177.78
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	557,122,643.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>278,561,321.50</b>	<b>629,338,847.52</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,143,118.00	26,453,687.52
210302	Түлш, халаалт	263,319,203.50	601,820,160.00
210303	Цэвэр, бохир ус	99,000.00	1,065,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>49,876,815.00</b>	<b>60,809,461.00</b>
210502	Хоол, хүнс	49,876,815.00	60,809,461.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,382,100.00</b>	<b>2,418,500.00</b>
210604	Урсгал засвар	3,382,100.00	2,418,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,507,531.00</b>	<b>19,335,902.32</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,286,700.00	4,129,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,220,831.00	15,206,002.32
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>202,933,769.89</b>	<b>543,029,585.44</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,571,609.00	99,546,432.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,670,394.35	34,445,931.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,691,766.54	409,037,221.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>116,998,363.50</b>	<b>156,725,728.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>116,988,685.00</b>	<b>128,310,176.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	116,988,685.00	128,310,176.00
<b>2134</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9,678.50</b>	<b>28,415,552.48</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,678.50	28,415,552.48
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>9,457,984,052.98</b>	<b>228,561,403.94</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>12,265,080.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	12,265,080.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(12,265,080.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>9,457,984,052.98</b>	<b>216,296,323.94</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,306,560,200.00</b>	<b>3,763,233,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,531,700.00</b>	<b>5,339,900.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	5,531,700.00	5,339,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,531,700.00	5,339,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,286,700.00	4,129,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	245,000.00	1,210,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>2,301,028,500.00</b>	<b>3,757,893,300.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,018,464,900.00	3,097,139,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,018,464,900.00	3,097,139,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	282,563,600.00	660,753,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	282,563,600.00	660,753,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,285,093,229.13</b>	<b>3,516,419,408.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,285,093,229.13</b>	<b>3,516,419,408.62</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,162,279,825.63	3,371,841,276.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,492,257,192.00	2,192,827,728.52
210101	Үндсэн цалин	837,976,588.00	1,389,022,671.65
210102	Нэмэгдэл	465,971,401.00	738,211,906.87
210104	Урамшуулал	14,172,648.00	65,593,150.00
210105	Гэрээт ажлын хөлс	174,136,555.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	187,618,882.13	274,031,672.78
210201	Тэтгэврийн даатгал	127,581,039.58	186,341,320.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,009,400.38	21,922,337.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,007,750.85	10,961,419.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,001,765.08	10,961,419.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,018,926.24	43,845,177.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,561,321.50	629,338,847.52
210301	Гэрэл, цахилгаан	15,143,118.00	26,453,687.52
210302	Түлш, халаалт	263,319,203.50	601,820,160.00
210303	Цэвэр, бохир ус	99,000.00	1,065,000.00
2105	Нормативт зардал	55,517,180.00	64,501,850.00
210502	Хоол, хүнс	55,517,180.00	64,501,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,992,600.00	2,999,300.00
210604	Урсгал засвар	3,992,600.00	2,999,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,726,531.00	56,015,902.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,286,700.00	4,129,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,439,831.00	51,886,002.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,606,119.00	152,125,975.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,422,619.00	128,012,625.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,183,500.00	24,113,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	122,813,403.50	144,578,132.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	122,803,725.00	116,162,580.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	122,803,725.00	116,162,580.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,678.50	28,415,552.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,678.50	28,415,552.48
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>21,466,970.87</b>	<b>246,813,791.38</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>21,466,970.87</b>	<b>246,813,791.38</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>195,837,684.47</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>442,651,475.85</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,651,465,570.52	423,033,061.72	9,816,876,732.82	11,891,375,365.06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,651,465,570.52	423,033,061.72	9,816,876,732.82	11,891,375,365.06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	216,296,323.94	216,296,323.94
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,651,465,570.52	423,033,061.72	10,033,173,056.76	12,107,671,689.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,958,208,300.00</b>	<b>3,488,003,856.14</b>	<b>470,204,443.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,958,208,300.00</b>	<b>3,488,003,856.14</b>	<b>470,204,443.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,820,428,800.00</b>	<b>3,371,841,276.14</b>	<b>448,587,523.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,548,299,200.00</b>	<b>2,192,827,728.52</b>	<b>355,471,471.48</b>
210101	Үндсэн цалин	1,614,563,700.00	1,389,022,671.65	225,541,028.35
210102	Нэмэгдэл	860,605,300.00	738,211,906.87	122,393,393.13
210104	Урамшуулал	73,130,200.00	65,593,150.00	7,537,050.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>318,537,400.00</b>	<b>274,031,672.78</b>	<b>44,505,727.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	216,605,400.00	186,341,320.00	30,264,080.00
210202	Тэтгэмжийн даатгал	25,483,000.00	21,922,337.00	3,560,663.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,741,500.00	10,961,419.00	1,780,081.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,741,500.00	10,961,419.00	1,780,081.00
210205	Эрүүл мэндийн даатгал	50,966,000.00	43,845,177.78	7,120,822.22
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>657,753,700.00</b>	<b>629,338,847.52</b>	<b>28,414,852.48</b>
210301	Гэрэл, цахилгаан	31,650,000.00	26,453,687.52	5,196,312.48
210302	Тулш, халаалт	596,803,700.00	601,820,160.00	(5,016,460.00)
210303	Цэвэр, бохир ус	29,300,000.00	1,065,000.00	28,235,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>70,211,600.00</b>	<b>64,501,850.00</b>	<b>5,709,750.00</b>
210502	Хоол, хүнс	70,211,600.00	64,501,850.00	5,709,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>2,999,300.00</b>	<b>700.00</b>
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,999,300.00	700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>63,660,700.00</b>	<b>56,015,902.32</b>	<b>7,644,797.68</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,248,300.00	4,129,900.00	118,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,412,400.00	51,886,002.32	7,526,397.68
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>158,966,200.00</b>	<b>152,125,975.00</b>	<b>6,840,225.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,794,700.00	128,012,625.00	6,782,075.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,171,500.00	24,113,350.00	58,150.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>137,779,500.00</b>	<b>116,162,580.00</b>	<b>21,616,920.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>137,779,500.00</b>	<b>116,162,580.00</b>	<b>21,616,920.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	137,779,500.00	116,162,580.00	21,616,920.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,958,208,300.00</b>	<b>3,734,817,647.52</b>	<b>223,390,652.48</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,097,139,600.00</b>	<b>3,097,139,600.00</b>	<b>-</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,097,139,600.00	3,097,139,600.00	-
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>660,753,700.00</b>	<b>632,338,147.52</b>	<b>28,415,552.48</b>
132001	Орон нутгийн төсвөөс	660,753,700.00	632,338,147.52	28,415,552.48
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>200,315,000.00</b>	<b>5,339,900.00</b>	<b>194,975,100.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,248,300.00	4,129,900.00	118,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	1,210,000.00	(1,000,000.00)
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	195,856,700.00		195,856,700.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>195,837,684.47</b>	<b>(195,837,684.47)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>442,651,475.85</b>	<b>(442,651,475.85)</b>

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар 2,458.9 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Илүү төлсөн ХХОАТ-ын 1830.9 мянган төгрөгийг авлагыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг анхан шатны баримтаас 627.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Аудитаар 5,681.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлээ.

#### **3.1 Төлбөрийн акт**

Байхгүй.

#### **3.2 Албан шаардлага**

Тайлант онд цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн 5,681.5 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлаас төлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

#### **3.3 Зөвлөмж**

Байхгүй.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
АО-с төлөх НДШ-г зардлыг илүү бүртгэсэн.	1	628.0			1	628.0	1	628.0				
ХХОАТ-г илүү төлснийг авлагаар бүртгээгүй.	1	1,830.9	1	1,830.9			1	1830.9				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,458.9</b>	<b>1</b>	<b>1,830.9</b>	<b>1</b>	<b>628.0</b>	<b>1</b>	<b>2,458.9</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эдийн засгийн ангилал зөрчсөн.	1	5,681.5			1	5,681.5						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>5,681.5</b>			<b>1</b>	<b>5,681.5</b>						

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
					Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 20

Дугаар 81-ХЭА-2025/125/НА-СТА-ТШЗ  
17925043 Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өмнөдэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн 5,681.5 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлж, эдийн засгийн ангилал зөрүүлэн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирал Ж.Сугаррагчаа, нягтлан бодогч М.Алтантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

"СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ"  
ХХК-ИЙН АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ



232504081